



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №14

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Өмнөд Солонгос, Ирланд, Голланд, Швед, Польш, ХБНГУ, Итали, Чех зэрэг улсын газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд бүртгэгдсэн. (Хүснэгт 1. Зураг 1. Шувууны томуугийн А хүрээний вирусн тархалт болон вирусн хэлбэр). Европын хэд хэдэн улс орныг хамруулж үнэлгээ хийхэд эрсдэл нэмэгдэж дундаж төвшинд хүрсэн. Генийн дараалал тогтоох судалгаагаар өмнөх жилүүдтэй харьцуулахад H5N1 вирусн нь хөхтөн амьтныг өвчлүүлэх болон хоруу чанар (нийт 240 хувьслын дүн) нэмэгдсэн.

https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/1032586/ai-risk-assessment-incursion-h5nx-hpai-housed-nohoused.pdf

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд БНХАУ-д өндөр хоруу H5N6 вирусээр үүсгэгдсэн 2 тохиолдол бүртгэгдэв.

Гуандонь аймгийн Дунгуань хотын иргэн 52 настай эрэгтэйд 10-р сарын 20 нд өвчний шинж тэмдэг илэрч тухайн өдрөө эмнэлэгт хандсан. Хунань аймгийн Юунжчоу хотын 58 настай эмэгтэйд 8-р сарын 29 нд өвчний шинж тэмдэг илэрч 8-р сарын 31 нд эмнэлэгт хандсан. Шинж тэмдэг илрэхээс өмнө шувууны аж ахуйд ажиллаж байсан. Өвчний биеийн байдал одоогоор хүнд байна гэж Хонконгийн Эрүүл мэндийг хамгаалах төвөөс мэдээлсэн. 2014 оноос хойш энэхүү дэд хэвшинжээр БНХАУ-д нийт 51 тохиолдол бүртгэгдээд байна. Үүнээс 2021 он гарсанаас хойш 27 тохиолдол бүртгэгдэв. Ихэвчлэн шувууны аж ахуй ажиллаж байсан, амьд шувууны худалдааны төвөөр орсон иргэд халдвар авсан. Хүнээс хүнд халдвар дамжсан тохиолдол бүртгэгдээгүй боловч судлаачид тандалт судалгааг хийж, нөхцөл байдлыг сайтар хянаж байна гэж мэдээлсэн.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

ДОЛОО. Шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

НАЙМ. Шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


ЕС. 2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон шувууны мэдээлэл (Хүснэгт 1):

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусын тархалт болон вирусын хэлбэр

№	Мэдээлсэн өдөр	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвш инж	Улс	Муж, газрын нэр	Өртсөн нийт хүн, шувуудын тоо	Тайлбар
1	5/11/2021	26/10/2021	H5N1	Өмнөд Солонгос	Диоксан Ри	1	Мандир уранхажин
2	5/11/2021	26/10/2021	H5N1	Өмнөд Солонгос	Юнгжон Ри	1	Мандир уранхажин
3	5/11/2021	1/11/2021	H5N1	Чех	Лужнице гол	2	Гунгар хун
4	5/11/2021	29/10/2021	H5N1	Ирланд	Орамор	1	Эгэл шонхор
5	5/11/2021	25/10/2021	H5N1	Голланд	Шервоод	5	Гургуул
6	5/11/2021	26/10/2021	H5N1	Швед	Малмо	1	Галуу
7	8/11/2021	26/10/2021	H5N1	Польш	Вежвайс	7000	Тахиа
8	8/11/2021	5/11/2021	H5N1	Польш	Копениця	384	Тахиа
9	1/11/2021	29/8/2021	H5N6	БНХАУ	Юунжчоу	1	58 настай эмэгтэй
10	1/11/2021	29/9/2021	H5N6	БНХАУ	Дунгуань	1	58 настай эмэгтэй
11	9/11/2021	6/11/2021	H5N1	Герман	Хозенкирхен	48	Тахиа
12	9/11/2021	28/10/2021	H5N1	Итали	Ровато	2	Зээрд нугас, Зэрэг нугас

Эх сурвалж: www.poultrymed.com, Cidrap.umn.edu

(Зураг 1) 2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусн тохиолдлын тархалт, Монгол орныг дайран өнгөрөх нүүдлийн шувуудын томоохон замууд /зургаар/



АРАВ. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдлын мэдээлэл:

2021 оны 10-р сарын 29 нөөс 11-р сарын 11 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.